



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 10 сарын 06 өдөр

Дугаар A/77

Улаанбаатар хот

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 81 дүгээр зүйлийн 81.5.1, 81.5.2, 81.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Төрийн эрон сууцны корпораци” төрийн өмчтэй хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Баяр-Эрдэнэ

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга

Гишүүд:

Ц.Гансүх

Барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга /зөвшилцсөнөөр/

Т.Дэлгэрмаа

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Б.Амарбаясгалан

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичиг:

Г.Нямдаваа

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

2. Сонгон шалгаруулалтыг холбогдох журамд заасны дагуу зохион байгуулж, тайланг 2023 оны 10 дугаар сард багтаан танилцуулахыг Ажлын хэсгийн дарга /Ц.Баяр-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

132013711